

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ СУРВАЛЖЛАН ОЛОХ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт Соёлын биет бус өв (цаашид СББӨ гэх), түүнийг өвлөн уламжлагчийг сурвалжлан олох, судлан шинжлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй гүйцэтгэх, гүйцэтгэлд хяналт тавих, холбогдох баримтыг зохих шаардлагын дагуу бүрдүүлж бүртгэл мэдээллийн үүсгэх, судалгааны хэрэглэгдэхүүн болгох, судлаач, судалгааны байгууллага болон өвлөн уламжлагчийн хоорондын харилцааг зохицуулах, өвлөн уламжлагчийн эрх ашгийг хамгаалах, СББӨ-ийг хамгаалахад судлаач, эрдэм шинжилгээний байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэхэд журмын зорилго оршино.

1.2. СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх ажил нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, СББӨ-ийг өвлөн уламжлагч хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн өвлөн эзэмшсэн ур чадвар, уламжлалт мэдлэг, ёс заншил, зан үйл, үзэл санааг хүндэтгэх зарчимд тулгуурласан байна.

1.3. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд болон гадаадын иргэн, судалгааны баг, эрдэм шинжилгээний байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэр дээр СББӨ (угсаатны зүй, нийгэм-соёлын антропологи)-ийн судалгаа шинжилгээний ажил хийхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.4.СББӨ-ийг сурталчлах нийтийг хамарсан арга хэмжээг шууд дамжуулах, дүрс бичлэг хийхэд энэхүү журам хамаарахгүй.

Хоёр.Нэр томьёо

2.1. Журамд хэрэглэсэн нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. **“СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ”** гэж Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 7.1 дэх хэсэгт заасан СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг шинжлэх ухааны батлагдсан онол, аргазүйн дагуу эрж хайх, бүртгэх, баримтжуулах, судалж шинжлэх үйл ажиллагааг;

2.1.2. **“Мэргэжлийн судалгааны баг”** гэж угсаатны зүй, антропологи, соёлын өв, түүх, монгол судлал, монгол хэл, аман зохиолын чиглэлээр судалгааны ажил хийж байсан туршлага бүхий 2 ба түүнээс дээш иргэдийн нэгдлийг (Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу гэрээ байгуулсан);

Мэргэжлийн судалгааны баг нь “дотоодын” болон “хамтарсан” гэсэн хэлбэртэй байж болно.

2.1.3. **“Хамтарсан баг”** Монгол Улсын эрх бүхий мэргэжлийн судлаач, судалгааны байгууллагатай хамтарсан судалгаа, шинжилгээ хийхээр гэрээ эрхзүйн

хувьд тохиролцсон гадаадын судлаач, эрдэмтэн, эрдэм шинжилгээний байгууллагаас зохион байгуулалтад орсон багийг;

2.1.4. **“Мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага”** гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-т заасан СББӨ-ийн хайгуул, судалгаа хийдэг хуулийн этгээдийг;

2.1.5. **“Мэргэжлийн судлаач буюу эрдэм шинжилгээний ажилтан”** гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.7-д заасан шинжлэх ухаан, технологийн тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэдэг мэргэшсэн судлаачийг;

2.1.6. **“Мэргэжлийн зөвлөл”** гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт СББӨ-ийн судалгаа хийх зөвшөөрөл олгох эсэх, СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг тогтоох, урамшуулах, СББӨ-ийг өвлүүлэн хөгжүүлэх, хамгаалах талаар санал боловсруулж Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд зөвлөх үүрэг бүхий орон тооны бус нэгжийг;

2.1.7. **“Зөвшөөрөл”** гэж Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, судалгааны баг, гадаадын иргэн, судалгааны баг, эрдэм шинжилгээний байгууллагад олгох баримт бичгийг хэлнэ.

Гурав.Судалгаа шинжилгээ хийх

3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт СББӨ-ийн судалгааг мэргэжлийн судлаач (цаашид судлаач гэх), эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны баг болон “хамтарсан баг” зохион байгуулж болно.

3.2. Гадаадын иргэн, судалгааны баг, эрдэм шинжилгээний байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээний ажил эрхлэн явуулахдаа Монгол Улсын эрх бүхий мэргэжлийн судлаач, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны багтай хамтран “хамтарсан баг” (гэрээгээр баталгаажсан байх) байгуулан оролцоно.

3.3 СББӨ-ийг “СББӨ-ийн бүртгэл”-ийн маягт, түүнийг өвлөн уламжлагчийг “СББӨ-ийг өвлөн уламжлагчийн бүртгэл”-ийн маягтын дагуу анхан шатны байдлаар бүртгэсний үндсэн дээр судлах ажлыг зохион байгуулна.

3.4. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас СББӨ-ийг яаралтай авран хамгаалах зорилгоор зорилтот судалгааг мэргэжлийн судлаач, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны багт захиалга өгөн гүйцэтгүүлж болно.

3.5. Судалгааг хийхдээ тухайн СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн харьяалах нутаг дэвсгэрийн Засаг захиргаанд заавал мэдэгдсэн байна.

3.6. Мэргэжлийн судлаач, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны баг болон “хамтарсан баг” нь зөвшөөрөлд дурдсан цаг хугацаа, нутаг дэвсгэрт судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэнэ.

3.7. Судалгаа, шинжилгээний ажлын явцад СББӨ-ийг өвлөн уламжлагчийн ур чадварт тохируулан урамшуулж болно.

Дөрөв. Тавигдах шаардлага

4.1 СББӨ-г сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх мэргэжлийн судлаач, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны баг нь дор дурдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.2 Мэргэжлийн судлаач

4.2.1 СББӨ, угсаатны зүй, нийгэм-соёлын антропологи, соёлын өв, түүх, монгол судлал, монгол хэл, аман зохиол судлалын чиглэлээр их дээд сургууль төгссөн байх,

4.2.2 Дээр дурдсан чиглэлээр магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэг хамгаалсан байх,

4.2.3 СББӨ-ийн чиглэлээр 5-аас доошгүй жил судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийсэн туршлагатай байх,

4.2.4 Судалж буй СББӨ-ийн чиглэлээрээ 3-аас доошгүй эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байх.

4.3.Эрдэм шинжилгээний байгууллага

4.3.1 СББӨ-ийн судалгааны чиглэл, зорилго, хүрэх үр дүнг тодорхойлсон, ойрын, дундын, хэтийн бодлого төлөвлөлттэй, мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх.

4.3.2 Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг эрдэмтэн судлаач, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран СББӨ-г сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах.

4.3.3 Эрдэм шинжилгээний байгууллага нь хамтарсан болон бие даасан судалгааны багийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий удирдагч (тухайн байгууллагын орон тооны ажилтан, салбартаа 10-аас доошгүй жил ажилласан, СББӨ-ийн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан Монгол Улсын иргэн), судалгааны багийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг бүхий эрдэм шинжилгээний ахлагчтай (тухайн байгууллагын орон тооны ажилтан, уг салбарт 5-аас доошгүй жил ажилласан, СББӨ-ийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн, магистраас дээш зэрэгтэй Монгол Улсын иргэн) байх.

4.4. Судалгааны баг

4.4.1 Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр зохион байгуулагдсан байх;

4.4.2 Багийг төлөөлөх удирдагчтай байх;

4.4.3 Удирдагч нь тухайн салбарт 10-аас доошгүй жил ажилласан, СББӨ (угсаатны зүй, антропологи)-ийн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан байх.

4.4.4 Гишүүдийн 50-иас доошгүй хувь нь СББӨ (угсаатан зүй, антропологи)-ийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн байх;

4.4.5 Гишүүн нь соёлын болон шинжлэх ухааны холбогдолтой хууль

тогтоомжийг зөрчиж захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх;

4.4.6 Судалгаа шинжилгээний ажил хийх санхүүгийн болон техник тоног төхөөрөмжийн чадамжтайгаа нотолсон байх.

4.5. Хамтарсан баг

4.5.1 Монгол Улсын эрх бүхий мэргэжлийн судлаач, судалгааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байх.

4.4.7 Багийг төлөөлөх удирдагчтай байх;

4.4.8 Удирдагч нь тухайн салбарт 10-аас доошгүй жил ажилласан, СББӨ (угсаатны зүй, антропологи)-ийн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан, Монгол Улсын иргэн байх.

4.4.9 Гишүүдийн 50-иас доошгүй хувь нь СББӨ (угсаатан зүй, антропологи)-ийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн байх;

4.4.10 Гишүүн нь соёлын болон шинжлэх ухааны холбогдолтой хууль тогтоомжийг зөрчиж захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх;

4.4.11 Судалгаа шинжилгээний ажил хийх санхүүгийн болон техник тоног төхөөрөмжийн чадамжтайгаа нотолсон байх.

Тав. Зөвшөөрөл олгох

5.1. СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх зөвшөөрлийг судлаач, судалгааны баг, эрдэм шинжилгээний байгууллага болон хамтарсан багт олгоно.

5.2. СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх зөвшөөрөл авах хүсэлтээ судлаач, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны баг болон хамтарсан баг нь тухайн жилийн 3 дугаар сарын 1-ний дотор соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад бичгээр гаргана. Хүсэлтэд дараах баримт бичгийг заавал хавсаргасан байна.

5.2.1. Тухайн СББӨ-ийг өвлөн уламжлагч, бүлэг, хамт олноос сайн дурын үндсэн дээр судалгаанд оролцохыг хүлээн зөвшөөрснийг илтгэх баримт бичиг (эсвэл зөвшилцсөнийг тодорхойлох баримт бичиг) авсан байх.

5.2.2 Өмнө нь гүйцэтгэсэн судалгааны ажлын товч танилцуулга болон судалгааны ажлын тайланг Соёлын өвийн үндэсний төвд хүлээлгэн өгсөн эсэх лавлагаа.

5.2.3. Удирдамж /судалгаа шинжилгээ хийх үндэслэл, хэрэгцээ шаардлага, зорилго, хамрах хүрээ, судалгааны нарийвчлалсан төлөвлөгөө, маршрут, бүрэлдэхүүн-судалгаа хийх мэргэжлийн эрдэмтэн, судлаачдын танилцуулга, урьдчилсан үр дүн гэх мэт мэдээллийг багтаасан байх/

5.2.4 Судалгаа, шинжилгээ явуулах эрдэм шинжилгээний байгууллагын гэрчилгээ, судлаачын дипломын хуулбар хувь;

5.2.5 Гэрээний хуулбар /хамтарсан судалгааны баг ажиллах тохиолдолд гадаадын иргэн, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр

байгуулсан гэрээ, гэрээний Монгол хэл дээрх орчуулга, байгууллагын гэрчилгээ, судлаачын дипломын хуулбар/;

5.2.6 Анх удаа судалгаа шинжилгээ хийх хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд энэ журмын 5.2.2-т заасан лавлагаа хамаарахгүй.

5.3. Хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх “СББӨ-ийн мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж, санал дүгнэлт гаргуулна.

5.4. Мэргэжлийн зөвлөлийн хурлаас гарсан санал дүгнэлтийг Соёлын асуудал асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж шийдвэр гаргуулна.

5.5. Соёлын асуудал асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний гаргасан шийдвэрийг үндэслэн СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх зөвшөөрлийг “Мэргэжлийн зөвлөл”-ийн дарга хавсралтад заасан маягтын дагуу үйлдэж судлаач, судалгааны баг, эрдэм шинжилгээний байгууллага болон хамтарсан багт олгоно. Зөвшөөрөлд судалгаа шинжилгээ хийх нутаг дэвсгэр, цаг хугацааг заавал бичнэ.

5.5.1 Зөвшөөрөлд судлаач, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны баг, хамтарсан багийн нэр (удирдагчийн нэр), судалгааны ажил хийх засаг захиргааны нэгжийн нэр, судалгаа зохион байгуулах газар нутгийн хамрах хүрээ, СББӨ-ийн нэр (өвлөн уламжлагчийн нэр тодорхой тохиолдолд бичих), судалгааны ажлын эхлэх дуусах хугацааг заавал бичнэ.

5.6. Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга зөвшөөрөл олгосон шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан судалгаа зохион байгуулагдах талаарх мэдээллийг аймаг, Нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

5.7. Тухайн СББӨ-ийг судлахаар нэг жилд хоёр ба түүнээс дээш эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, судалгааны баг хүсэлт гаргасан тохиолдолд өмнөх судалгааны ажлын туршлагыг харгалзан үзэж, зөвшөөрлийг олгоно.

5.8. Хилийн бүс, хилийн зурваст СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээг хийхдээ Монгол Улсын Хилийн тухай хуулийн 30.2.3 дахь хэсэгт заасны дагуу холбогдох зөвшөөрлийг авна.

Зургаа. Зөвшөөрөлд өөрчлөлт оруулах

6.1. Судалгаа зохион байгуулах газарт гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйл учирсан, хорио цээрийн дэглэм тогтоосон тохиолдолд зөвшөөрөлд өөрчлөлт оруулах хүсэлтийг Мэргэжлийн зөвлөлд гаргаж болно.

6.2. Мэргэжлийн зөвлөл хүсэлтийг хурлаараа хэлэлцэж, зөвшөөрлийн хугацаанд өөрчлөлт оруулах эсэх талаар гаргасан саналаа Соёлын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд танилцуулж шийдвэр гаргуулна.

6.3. Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга энэ журмын 6.2-т заасан шийдвэрийг ажлын 5 хоногт багтаан харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

Долоо. Хориглох, зөвшөөрлийг цуцлах

7.1. Судлаач, судалгааны байгууллага, судалгааны баг, хамтарсан баг дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно.

7.1.1. Улс төр, шашны зүтгэлтнийг сурталчлах;

7.1.2. Улс төрийн нам болон түүний үзэл баримтлал, шашин болон түүний урсгалыг сурталчлах, шашин мөргөлийн зан үйлд орох, нэгдэхийг ятгах;

7.1.3. Угсаатны бүлэг, хамт олон, хувь хүний амьдралын хэвшил, мэдлэг ухаан, ур чадвар, шашин шүтлэг, ёс заншил, зан үйлийг гутаах, дорд үзэх, ялгаварлан гадуурхах;

7.1.4. Хувь хүний нууцад хамаарах мэдээлэл цуглуулах;

7.1.5. Удирдамжид зааснаас өөр зорилгоор судалгаа хийх;

7.2. Энэ журмын 7.1-т заасан үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт СББӨ-ийг сурвалжлан олох судалгаа шинжилгээ хийх зөвшөөрлийг цуцалж, дахин зөвшөөрөл олгохгүй.

Найм. Судалгаа шинжилгээний ажлын үр дүнг тайлагнах

8.1 Эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны баг тухайн жилийн судалгааны ажлын тайланг 12 дугаар сарын 01-ний дотор соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүлээлгэн өгнө.

8.2.Тайлан нь дараах шаардлагад нийцсэн байна.

8.2.1.Тайлангийн бичвэрийг монгол хэлээр орчин цагийн монгол хэлний найруулга, хэл зүйд нийцүүлэн бичсэн байх;

8.2.2.Судалгаа шинжилгээний ажлын үйл явц, үр дүнг бүрэн илэрхийлсэн байх (бичвэр, гэрэл зураг, видео бичлэг гэх мэт);

8.2.3. Удирдамж, гэрээ, лавлагаа, зөвшөөрөл зэрэг холбогдох баримт материалыг хавсаргасан байх;

8.2.4.Гадаад хэл дээрх баримтын монгол орчуулгыг хавсаргасан байх;

8.2.5.Судалгаа, шинжилгээ хийсэн СББӨ-ийн төрөл зүйл, түүнийг өвлөн уламжлагчдыг хамгаалах, цаашдын оршин тогтнох чадварыг хангахад зориулан санал зөвлөмж гаргасан байх.

8.3. Судлаач болон хамтарсан баг судалгааны ажлын товч мэдээллийг судалгааны ажил дууссанаас 3 сарын дотор цаасан болон цахим хэлбэрээр соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8.4. Товч мэдээлэл дараах шаардлагад нийцсэн байна.

8.4.1.Товч мэдээллийг монгол хэлээр орчин цагийн монгол хэлний найруулга, хэл зүйд нийцүүлэн бичсэн байх;

8.4.2.Судалгаа шинжилгээний ажлын үйл явц, үр дүнгийн талаарх мэдээллийг багтаасан байх (бичвэр, гэрэл зураг, видео бичлэг гэх мэт);

8.4.3. Удирдамж, гэрээ, лавлагаа, зөвшөөрөл зэрэг холбогдох баримт материалыг хавсаргасан байх;

8.4.4.Гадаад хэл дээрх баримтын монгол орчуулгыг хавсаргасан байх;

8.4.5.Судалгаа, шинжилгээ хийсэн СББӨ-ийн төрөл зүйл, түүнийг өвлөн уламжлагчдыг хамгаалах, цаашдын оршин тогтнох чадварыг хангахад зориулан санал зөвлөмж гаргасан байх.

8.5.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тайлан болон судалгааны ажлын товч мэдээллийг “Мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж, тухайн СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг хамгаалах бодлого, арга хэмжээнд тусгах эсэх санал, дүгнэлтийг гаргана.

8.6.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тайланг нэгтгэсэн танилцуулгын хамт Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлж хадгалуулна.

8.7.Соёлын өвийн үндэсний төв тайланг судлаач, судалгааны хүрээлэн, судалгааны баг болон хамтарсан багийн зөвшөөрөлд үндэслэн СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор бусдад ашиглуулж болно.

8.8 Монгол Улсын их, дээд сургуульд суралцагч СББӨ-ийн чиглэлээр магистр, докторын эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн тохиолдолд судалгааны ажлын мэдээллийг тухайн жилийн 12 дугаар 01-ний дотор зэрэг горилж буй их, дээд сургууль хариуцан Соёлын өвийн Улсын Нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлнэ.

Ес. Дэмжлэг үзүүлэх хэлбэрүүд

9.1 Судлаач судалгааны ажлын тайлангийн хураангуйг Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэн өгснөөр СББӨ-ийн судлаачдын санд шууд бүртгэгдэж, хамтарсан болон захиалгат судалгаанд оролцох боломж бүрдэнэ.

9.2 СББӨ-ийн судалгааны үр дүнг ашиглан хамтарсан ном, бүтээл гаргах боломж бүрдэнэ.

9.3 Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн үндэсний бүртгэлд орсон өвийг судлах, судалгаа шинжилгээ хийх тохиолдолд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын нэгж дэмжлэг үзүүлж болно.

9.4 СББӨ-ийн судалгаа, шинжилгээнд хамрагдсан өвлөн уламжлагчдыг урамшуулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг дарга нар Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16.1.12 дахь хэсэгт заасны дагуу зохион байгуулж болно.

Арав. Хяналт тавих

10.1.Тус журмын дагуу судалгаа шинжилгээ хийх зөвшөөрөл авсан судлаач, судалгааны байгууллага, судалгааны баг болон хамтарсан багаас судалгаа шинжилгээ хийхтэй холбогдуулан төлбөр, хураамж авахыг хориглоно.

10.2. СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх үйл ажиллагаанд сум, дүүргийн Засаг дарга болон түүний дэргэдэх соёлын нэгж хяналт тавина.

10.3. Судлаач, судалгааны байгууллага, судалгааны баг болон хамтарсан баг журмын 7.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга судалгаа шинжилгээний ажлыг шууд зогсоох эрхтэй бөгөөд судалгааны ажлыг зогсоосон тухайгаа соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

11. Бусад

11.1 Судлаач, судалгааны байгууллага, судалгааны баг болон хамтарсан багаас СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх зөвшөөрөл авах хүсэлтийг хүлээн авах, баримт бичгийн бүрдлийг хянах, мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, зөвшөөрөл олгох шийдвэр гаргуулах, зөвшөөрөл олгох, сум дүүргийн Засаг даргад мэдэгдэх, тайланг хүлээн авах, мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд танилцуулах, Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлэх арга хэмжээг СББӨ-ийн мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцан зохион байгуулна.

11.2 Судлаач, судалгааны байгууллага, судалгааны баг болон хамтарсан баг зөвшөөрөлгүйгээр СББӨ (угсаатны зүй, антропологи)-ийн судалгаа хийсэн тохиолдолд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 9.7.2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага тооцно.

№ СОЁЛЫН САЙДЫН 20 ... ОНЫ ... ДУГААР САРЫН ... -НЫ ӨДРИЙН ... ДУГААР ТУШААЛААР СУДЛААЧ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА, СУДАЛГААНЫ БАГ, ХАМТАРСАН БАГ- Т..... СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОВ. ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН: МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:() <i>Гарын үсэг нэрийн тайлал</i> 20 ... оны ... сарын ... өдөр	СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙХ: Засаг захиргааны нэгжийн нэр: Газар нутгийн нэр: СББӨ-ийн нэр: Өвлөн уламжлагч, бүлэг, хамт олны нэр:..... Хугацаа: 20 оны дугаар сарын -ны өдөр 20 оны дугаар сарын -ны өдөр <i>Энэхүү зөвшөөрөл нь зөвхөн зөвшөөрөлд бичигдсэн газар, хугацаанд хүчинтэй.</i>
---	--